



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 11/81

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газрын Зөвлөмжийг  
хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг  
хэрэгжүүлэн ажиллах тухай

Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох, авлигын эрсдэлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2022 оын 10 сарын 23-ны 1499 тоот зөвлөмжийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөмж ирүүлсэнтэй холбоотой дараах чиглэлээр, эрүүл мэндийн салбарт үүссэн авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэлийг арилгах, урьдчилан сэргийлэх, хавсралтанд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй томилосугай.


Ажлын хэсгийн ахлагч: Ц.Энхбаясгалан /ХНА-ны дарга, АТГ-ын ЭБАТ /  
Гишүүд: С.Оюун-Эрдэнэ /Санхүү албаны дарга /  
Т.Булгантамир /Дотоод хяналтын мэргэжилтэн/  
Д.Бат-Эрдэнэ /Хүний нөөцийн ажилтан/  
О.Дулмаа /Архив, бичиг хэргийн ажилтан/

3. Авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэлийг арилгах, урьдчилан сэргийлэх Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

4. Зөвлөмжийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг гаргах ажлын хэсгийн ахлагч /Ц.Энхбаясгалан /-д даалгасугай.

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ



3 170 7032264

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын  
2022 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн  
8/81 -р тушаалын нэгдүгээр хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх
Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийггүхэйн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл. албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк. твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх; 1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах; 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;		
Зорилго 2: Авлигын эсрэг сэргэлт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургадтад хамруулах	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ- т хүргүүлсэн байх;		

	<p>2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулсан байх</p> <p>2.3.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;</p> <p>2.4.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан бэйх;</p>		
Зорилго 3:	<p>Авлигатай тэмэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь гаргах</p> <p>3.1 Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх</p> <p>3.2 Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p> <p>3.3.Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>		
Зорилго 4:	<p>Байгууллагын удирдлагын авилгатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачлага өрнүүлэх</p> <p>4.1. Авлигын эсрэгтөрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгуул- лагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;</p> <p>4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах</p>		

	талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;		
Зорилго 5:	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамхслага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх. эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	
Зорилго 6:	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	6.1- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.14; - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6 4 - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан есны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах;	

БОЛОВСРУУЛСАН:

ХНА-ны ДАРГА, ЭБАТ ажилтан: *[Signature]* Ц.ЭНХБАЯСГАЛАН

